

“Солонгос судлал-2025” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын удирдамж

НЭГ. Зорилго

Солонгос судлалын чиглэлээр суралцаж буй магистр, докторын хөтөлбөрийн оюутнуудыг судалгааны шинжилгээний ажилд дадлагажуулах, практик дадлага олгох, эрдмийн ажлыг урамшуулан дэмжих, харилцан санал туршлага солилцох, сурталчлан таниулахад оршино.

ХОЁР. Сэдвийн хамрах хүрээ

Солонгос судлалын бүх салбарын чөлөөт сэдэв

ГУРАВ. Ерөнхий шаардлага

- Их дээд сургуулийн докторант, магистрантаар суралцаж буй оюутан байх(багаар оролцож болно)
- Судалгааг монгол, солонгос хэлний аль нэгээр бичиж, хэлэлцүүлэх
- Шинжлэх ухааны онолын үндэслэлтэй байх
- Тодорхой асуудлыг хөндсөн байх
- Баталгаат эх үүсвэр бүхий эшлэл авсан байх
- Практик ач холбогдолтой байх, бүтээлч сэтгэлгээгээр хандсан байх
- Бусдын ажлыг хуулбарлаагүй байх

ДӨРӨВ. Хурлын зохион байгуулалт

- Хурал зөвхөн танхимаар зохион байгуулагдана.
- Нэгдүгээр шат: Судалгааг файл хэлбэрээр 2025.04.23-ны дотор хүлээн авч, дүгнээд дараагийн шатанд шалгарсан оролцогчид имэйлээр 2025.04.25-нд мэдэгдэнэ
- Хоёрдугаар шат: Эхний шатанд шалгарсан судалгааг 2025.05.01(Пүрэв)-нд хэлэлцүүлж шагналт байрыг шалгаруулна.
- Хоёрдугаар шатанд хэлэлцүүлэх илтгэлийг MS-Power Point программ ашиглан бэлтгэн, илтгэлийг 10 минутад багтаан хэлэлцүүлнэ.

ТАВ. Бичвэрт тавигдах шаардлага

- Бичвэр нь дараах бүтэцтэй байна
 - Судалгааны сэдэв
 - Судлаачийн овог нэр, харьяа сургууль, тэнхим, хөтөлбөрийн нэр, цахим шуудангийн хаяг, утасны дугаар
 - Хураангуй(5-10 өгүүлбэр)
 - Удиртгал
 - Үндсэн хэсэг
 - Дүгнэлт(дэвшүүлсэн санаа багтах)
 - Ашигласан материалын жагсаалт
- Тавигдах шаардлага
 - Судалгааг монгол хэлээр бичих бол Microsoft Office Word(Hangul эсвэл Hancom Office программ ашиглахгүй) программын Arial фонд, солонгос хэлээр бичих бол Microsoft Office Word(Hangul эсвэл Hancom Office программ ашиглахгүй) программын Batang фонтоор үсгийг 12, мөр хоорондын зай 1.15, А4 хэмжээтэй цаасны дээр, доороос 2.0 зайтай 6-10 нүүр байна
 - Судалгааны сэдвийг 14 хэмжээтэй bold форматтай бичих ба, зураг, хүснэгт бүгд дугаар нэртэй байх хуудасны голд байрлана
 - Тайлбар зүүлт ашигласан байх ба монгол, солонгос хэлний үг үсгийг алдааг судлаач өөрөө засч илгээнэ.

ЗУРГАА. Материал хүлээн авах

- Судалгааны файлыг **2025 оны 04 сарын 23-ны 12 цаг хүртэл** koreanstudies@ulaanbaatar.edu.mn хаягаар хүлээн авна. Файлыг драйв хэлбэрээр илгээж болохгүй.
- Судалгааг илгээхдээ судлаачийн овог нэр, сургууль, тэнхимийн нэр, утасны дугаарыг тодорхой бичиж илгээнэ.